



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/25

Хажуу шинэ-Ус

Н.Өлзийтогтох -д сахилгын шийтгэл ногдуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8 дахь заалт, 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1 дахь заалт, Дундговь аймаг дахь төрийн аудитын газрын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 55/A/1270315 дугаартай албан шаардлагыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох нь аудитаар өгөгдсөн өмнөх зөрчил арилгуулах албан шаардлагын бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй нь 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 55/A/1270315 албан шаардлагаар тогтоогдож байх тул түүнд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг явуулсан болохыг дурдсугай.

3.Цаашид албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийг ханган, нягтлан бодогч У.Сүнжидмаагийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

4.Н.Өлзийтогтох энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ДАРГА  Т.АРИУНАА

482401025

МЭДЭГДЭЛ

2024.03.21

Хажуу шинэ ус

Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох-д Сонсох ажиллагаа явуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т (Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна.) 26, 27 дугаар зүйлд тус тус заасны дагуу:

1.Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох нь аудитаар өгөгдсөн өмнөх зөрчил арилгуулах албан шаардлагын бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй нь 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 55/A/1270315 албан шаардлагаар тогтоогдож байх тул түүнд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэл ногдуулах болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2024 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 11 цагт сонсох ажиллагааг биечлэн явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

- 1.Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах
- 2.Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах

Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Засаг дарга...../Т.Ариунаа/  
Албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан...../Н.Өлзийтогтох/  
Албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: 2024.03.21

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ  
ТЭМДЭГЛЭЛ

№...01....

2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

Хажуу шинэ ус

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11:00 цагт Засаг даргын албан ерөөнд биечлэн сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох, Засаг дарга Т.Ариунаа нар оролцлоо.

Татгалзаж байгаа шалтгаан:.....гарын үсэг.....

Зөвшөөрч байна. Гарын үсэг.....

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох танилцуулав.

Асуулт: Засаг дарга Т.Ариунаа

Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох-д Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн захирамжыг танилцуулан хяналт тавиагүй зөрчилд Монгол Улс Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8 дахь заалт, 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1 дахь заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах захирамж танилцууллаа.

Хариулт: Н.Өлзийтогтох Цаашид ажилтандаа маш сайн хяналт тавьж алдаа зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.

Сонсох ажиллагааг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11:25 цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл:...../Т.Ариунаа/

Оролцогч:...../Н.Өлзийтогтох/